

Сэдэв: Агаарын ТЭЭВЭРЛЭЛТ



Олон улсын агаарын тээвэрлэлт гэдэг нь шилжүүлэн ачилт ба түр буулт хийж буй эсэхээс үл хамааран, нэг орны нутаг дэвсгэрт оршин буй ачилт хийх цэгээс нөгөө орны нутаг дэвсгэрт оршин буй буулгах цэгийн хооронд нисэх онгоцоор үйлдэж буй аливаа тээвэрлэлтийг хэлнэ.

Энэ төрлийн тээвэрлэлт нь дэлхийн аль ч орон руу богино хугацаанд үнэт болон түргэн хүргэх ачаа, хурдан мууддаг хүнсний зүйлс, цэцэг болон бусад барааг тээвэрлэхэд ашиглагдаж байна.

- Өндөр үнэтэй, бага хэмжээний бараа тээвэрлэхэд тохиромжтой
- Бараа бүтээгдэхүүнд ямар нэгэн эвдрэл гэмтэл гарах нөлөөлөл бага
- Хурдан шуурхай
- Дунд зэргийн эсвэл хол зайнд тээвэр хийхэд ашигтай
- Ачаа барааны баглаа хялбар

- Их хэмжээний бүтээгдэхүүн тээвэрлэх боломжгүй, жин, хэмжээний хязгаартай
- Зардал өндөр
- Цаг агаарын нөлөө их
- Нисэх онгоцны буудлууд ихэвчлэн үйлдвэрлэгчийн агуулахаас болон хүлээн авагчийн байршлаас хол байрладаг

- Олон улсын агаарын тээвэрлэлтийг үйлдэж буй хэлбэрээр нь 2 хуваана:
 - ✓ Байнгын тээвэрлэлт
 - ✓ Байнгын бус тээвэрлэлт
- Байнгын тээвэрлэлт гэдэг нь агаарын тээврийн сүлжээний талаар олон улсын хэмжээний хооронд байгуулсан гэрээ хэлэлцээрийн дагуу тогтоосон хуваариар, тодорхой чиглэлд үйлдэж буй тээвэрлэлтийг хэлнэ. Тээвэрлэлт хийх нислэгийн хуваарьт замын маршрут, замд түр буудаллах цэгүүд, маршрутын цэгүүдэд буух хугацаа ба тэдгээр цэгүүдээс хөөрөх хугацаа, нислэг үргэлжлэх хугацаа, онгоцны төрөл зэргийг тусгадаг
- Байнгын бус тээвэрлэлт гэдэг нь нислэгийг үйлдэх нэг удаагийн тусгай зөвшөөрлийн дагуу хийж буй тээвэрлэлт юм

- Олон улсын агаарын тээврийн байнгын тээвэрлэлтэд зарласан ба зарлагдаагүй тарифыг хэрэглэдэг
 - ✓ Зарласан тариф бол агаарын ачаа тээврийн тарифын лавлахад нийтлүүлсэн бөгөөд тээвэрлэлт эхлэх буудлаас хүрэх буудал хүртэл ачааг зөөвөрлөсний төлөө хураан авдаг татвар хураамж юм. Хэрэв хоёр орны буудлуудын хоорондох тээвэрт зарласан тарифыг хэрэглэж байгаа бол ямарваа ачааг тээвэрлэхэд зөвхөн үүнийг л мөрдөнө
 - ✓ Зарлагдаагүй тарифыг агаарын тээврийн тухайн чиглэлд зарласан тариф байхгүй тохиолдолд ашигладаг



- Монгол Улсын нутаг дэвсгэрээс дараах агаарын тээврийн компаниуд гадаадын хотууд руу шууд нислэг хийж үйлдэж байна. Үүнд:

МИАТ

- Улаанбаатар-Бээжин, Улаанбаатар-Токио, Улаанбаатар-Сөүл, Улаанбаатар- Бусан, Улаанбаатар-Москва, Улаанбаатар-Берлин, Улаанбаатар- Франкфурт, Улаанбаатар-Хонгконг, Улаанбаатар-Бангкок

ХҮННҮ ЭЙР

- Улаанбаатар- Эрээн, Улаанбаатар- Бугат, Улаанбаатар-Манжуур, Улаанбаатар- Улаан-Үүд

АЭРО МОНГОЛИА

- Улаанбаатар-Эрхүү, Улаанбаатар-Хөх хот

КОРЭЙН ЭЙР

- Улаанбаатар-Сөүл

ЭЙР ЧАЙНА

- Улаанбаатар-Бээжин

ТУРКИШ ЭЙРЛАЙН

- Улаанбаатар-Истанбул

АЭРОФЛОТ

- Улаанбаатар-Москва



АНХААРАЛ ТАВЬСАНД БАЯРЛАЛАА

